

**ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(Эрүүл мэндийн салбар)**

Нэг. Үнэлгээний зорилго

"Шинэ сэргэлтийн бодлого" нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм. Энэхүү үнэлгээний зорилго нь хөтөлбөрийн эхний үе шатанд Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэх, цаашид авах арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулахад оршино.

Хоёр. Үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2 дахь заалтын дагуу үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Гурав. Үнэлгээний талаар

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн салбараас тухайлан хэрэгжүүлэх ажил тусгагдаагүй хэдий ч салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа, тухайн асуудалтай хамааралтай ажлуудыг нэгтгэн үнэллээ.

"Шинэ сэргэлтийн бодлого" нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны

хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийн эхний үе шатны үйл ажиллагаанд хамаарах эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлж байгаа 18 арга хэмжээг нэгтгэн үнэллээ. Үүнд:

- Боомтын сэргэлтийн хүрээнд - 1
- Аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд - 2
- Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд - 2
- Ногоон хөгжлийн сэргэлтийн хүрээнд - 5
- Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд - 8

Эдгээрээс 8 үйл ажиллагаа 100%-ийн хэрэгжилттэй, 4 үйл ажиллагаа 90%-ийн хэрэгжилттэй, 5 үйл ажиллагаа 70%-ийн хэрэгжилттэй, 1 үйл ажиллагаа 50%-ийн хэрэгжилттэй салбарын хэмжээнд хэрэгжилтийн дундаж хувь 86.7% байна. Үнэлгээгээр 50% буюу хамгийн бага хэрэгжилттэй ажлыг авч үзвэл:

“Аж үйлдвэрийн сэргэлт” бүлэг дэх “Нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг барихад эрчим хүчний хэмнэлттэй, саарал усыг дахин ашиглах технологийн шаардлагыг хангах” гэсэн үйл ажиллагааны хүрээнд “Эмнэлгийн барилга байгууламжид нүүрстөрөгчийн хийн ялгарал багатай технологи нэвтрүүлж эхлэх” гэсэн үйл ажиллагаа юм.

Эрүүл мэндийн салбарт АХБ-ны дэмжлэгтэй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төсөл хэрэгжиж байна. Энэ төслийн хүрээнд Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлэг, Увс, Ховд аймгийн нэгдсэн эмнэлэг, 10 өрхийн эрүүл мэндийн төв (Баянзүрх дүүргийн 2, Сонгинохайрхан дүүргийн 1, Чингэлтэй дүүргийн 2, Хан-Уул дүүргийн 3, Баянгол дүүргийн 2), 6 сумын эрүүл мэндийн төв (Архангайн Эрдэнэмандал, Булганы Дашинчилэн, Дорноговийн Эрдэнэ, Хөвсгөлийн Тариалан Ринчинлхүмбэ, Өвөрхангайн Баян-Өндөр), Үндэсний түргэн тусламжийн төвийн барилгын ажил 2019-2029 онд хийгдэхээр төлөвлөгдсөн байгаа. Эдгээр барилгуудыг барихад “нүүрстөрөгчийн хийн ялгарал багатай технологи” (LCT–Low carbon technology) нэвтрүүлэх бөгөөд энэ чиглэлээр Японы “Azusa Sekkei” компанитай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогоор ХУД-ийн Нэгдсэн эмнэлэг, ХУД-ийн 14-р хорооны ӨЭМТөвийн барилгын зурагт LCT технологи нэвтрүүлэхтэй холбоотой ажлын зураг, техникийн шаардлагуудыг сайжруулж боловсруулаад байна.

Үнэлгээгээр 70%-ийн хэрэгжилттэй 5 үйл ажиллагааны тухайд:

Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд:

1. Шаардлагатай боомтуудад байгалийн голомтот халдварын болон КОВИД-19 халдварын лаборатори байгуулах, үйл ажиллагааг хангах ажил төлөвлөгдсөн.

Уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги, Бичигт, Замын-Үүд автозамын боомтуудыг 2021-2022 онд БНХАУ-ын ЗГ-ын буцалтгүй тусламжаар бүрэн автомат ПГУ шинжилгээний төхөөрөмж (FQD-G1600)-ийн иж бүрдлээр болон удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан. Эдгээрээс Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтод Молекул биологийн суурин лаборатори (КОВИД-19-ын нуклейн хүчил ялгах, полимерадын гинжин урвалын) нь өдөрт дунджаар 800 орчим хүнд шинжилгээ хийх хүчин чадалтай лаборатори бөгөөд “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн үйлчлэх хугацааг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тул 2023 он гарсаар тус лабораторийн үйл ажиллагааг зогсоогоод байна.
- Шуурхай удирдлагын нэгжгүй Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Сүхбаатар, Увс гэсэн 13 аймагт нэгж байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах чиглэлээр ДЭМБ-тай хамтран ажиллаж, 18 нэр төрлийн 217 ширхэг 915,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.
- Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймагт Зоонозын өвчин судлалын төв байгуулах, Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Дорнод аймгийн Хавирга, Увс аймгийн Боршоо, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд, Ханги, Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Шивээхүрэн, Сүхбаатар аймгийн Бичигт хилийн боомтод тандалтын нэгж байгуулах үндэслэл, танилцуулга, санхүүжилтийн тооцоог хийсэн. “Орон нутагт зоонозын өвчин судлалын төв, Хилийн боомтод тандалтын нэгж байгуулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, байгууламж барихад шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг шийдвэрлэх тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал хүргүүлсэн боловч Төрийн хэмнэлтийн хуулийн зарчмын хүрээнд батлагдаагүй байна.

Аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогын хүрээнд:

2. Адууны дайвар түүхий эдийг экспортлох, импортлох үеийн хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протоколыг Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулах ажил төлөвлөгдсөн. Уг ажлын хүрээнд эрүүл мэндийн салбараас дараах ажлууд хийгдээд байна. Үүнд:

Хоол хүнсний аюулгүй байдлыг хангах, техникийн зохицуулалтыг шинэчлэн батлах ажлын хүрээнд Стандарт хэмжил зүйн газарт дараах стандартуудад санал хүргүүлж хамтран ажилласан. Үүнд:

- Сүүн, сүүн бүтээгдэхүүний стандартчиллын дэд хорооны хурлаар хэлэлцүүлэх 4 стандартын төсөлд санал боловсруулж, 2/1651 дугаар албан бичгээр СХЗГ-т санал хүргүүлсэн.
- Хүнсний стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх 2 стандартын төсөлд санал боловсруулж, 2/1650 дугаар албан бичгээр СХЗГ-т санал хүргүүлсэн.
- “Хүнсний боловсруулах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх (сүү, гурил, хоол үйлдвэрлэл) заавар”-ын төсөлд 1а/480 дугаар албан бичгээр ХХААХҮЯ-нд санал хүргүүлсэн.
- “MNS 7005: 2023 “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага” стандартыг боловсруулах ажлын хэсэгт хамтран ажилласан ба стандарт нь 2023 оны 5 дугаар сарын 3-нд батлагдсан.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оын 10-00-02/29 дугаартай “Улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу ХХААХҮЯ, ЭМЯ, БОАЖЯ-ны хамтарсан хяналтын ажлын хэсэг 21 аймаг 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй нийт 249 мах боловсруулах, мал төхөөрөх үйлдвэрүүдэд холбогдох журам, стандартын хэрэгжилтэд шалгалт хийж үнэлгээ дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хүргүүлж ажилласан. Шалгалтын мөрөөр ХААЯ-нд бодлого боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой холбогдох 15 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд:

3. Сумдын инженерийн дэд бүтцийн хангамжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж, хэрэглэгчдэд иж бүрэн, чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааны хүрээнд:

- Улсын хэмжээнд 330 сумын эрүүл мэндийн төвүүдийн ариун цэврийн байгууламжийн судалгааг бүрэн гаргаж дууссан. “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2019 оны судалгаа”-аар нийт сумын эрүүл мэндийн төвийн 19% нь төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон бол 81% нь хэсгийн усан хангамжийн системтэй байна. Сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн зураг төслийн даалгаврыг боловсруулан, нэг маягийн зураг төслийг 2022 онд боловсруулж дууссан. Санхүүжилтийн тооцоог боловсруулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусгуулахаар санал хүргүүлсэн боловч эх үүсвэр батлагдаагүй. Төсөл нь бусад салбарын ариун цэврийн байгууламж болон “Шинэ сум” төсөлтэй уялдах тул Барилга, хот байгуулалтын яаманд цогц хэлбэрээр хэрэгжүүлэх тухай хүсэлтийг хүргүүлсэн байна.

4. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулж, нөөцийн хуримтлал бий болгох ажлын хүрээнд:

- Эрүүл мэндийн яамнаас ундны усны чанар, аюулгүй байдалд жилд дунджаар 1600 гаруй дээжинд хими, нян судлалын үзүүлэлтээр шинжилгээ хийлгэн үнэлгээ дүгнэлт өгч ажиллаж байна. 2022-2023 онд онд нийт 1665 дээжинд шинжилгээ хийлгэсэн ба 8,2% нян судлалын үзүүлэлтээр, 21% нь химийн үзүүлэлтээр /хатуулаг, магни, төмөр/ ундны усны стандартын шаардлага хангахгүй гарч байна. Мөн хүнд металл болох хүнцлийн агууламж 17 сумын 34 худгийн ус, ураны агууламж 42 сумын 68 худгийн ус, хар тугалга 22 сумын 29 худгийн усанд стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их гарч байна. Фтор-ын агууламж шинжилгээнд хамрагдсан ундны усны эх үүсвэрийн 145 /17%/ худгийн усанд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их, 408 /51%/ худгийн усанд зөвшөөрөгдөх доод хэмжээнээс бага, 290 /32%/ худгийн усанд зөвшөөрөгдөх хэмжээнд байна. Ундны усны эх үүсвэрүүдэд хийсэн шалгалтаар Нийслэлийн төвлөрсөн ус хангамжийн Гачууртын, А, Б, В эх үүсвэр, аймаг сумын ундны усны эх үүсвэрийн худгийн

466 ба 31.2% нь бүсийн дэглэм зөрчсөн, мөн усан сангийн угаалга халдваргүйжүүлэлт хангалтгүй, төвлөрсөн ус хангамжийн усанд халдваргүйжүүлэлт хийдэггүй, шугам сүлжээний /ялангуяа шинэ барилга/ угаалга халдваргүйжүүлэлт хангалтгүй зэрэг зөрчлүүд илэрдэг. Мөн хөдөөгийн хүн ам хөдөө аж ахуйн зориулалтаар гаргасан /ундны бус/ эрүүл ахуйн шаардлага хангахгүй, шинжилгээ баталгаажилтгүй усыг хэрэглэж, өвлийн улиралд усны хомсдолд орж байгаагаас уснаас шалтгаалах өвчин эмгэгт өртөх нөхцөл бүрдсэн байна. Хяналт шалгалтын дүнд үдэслэн ус хангагч ААН-д жилд дунджаар 230 дүгнэлт, 36 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна.

5. Нийслэл хот болон аймгийн төвүүдэд хог хаягдлыг ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжиж, хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах ажлын хүрээнд:

- Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр-5 төслийн “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах” зорилтын хүрээнд орон нутагт 8 аймгийн (Дархан-Уул, Булган, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь, Дорноговь, Хэнтий, Увс) эмнэлгийн хог хаягдлын 521,3 м² талбай бүхий барилгын ажлыг нийтдээ 1,2 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэн, 2019-2020 онд байнгын ашиглалтанд оруулсан бөгөөд энэ жишгээр үлдсэн аймгуудад эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулахаар ажиллаж байна. Тухайлбал, Эрүүл мэндийн байгууллагуудын аюултай хог хаягдлын ангилан ялгалт, цуглуулалт, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, устгалын чадавхийг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор ХӨСҮТ, УГТЭ, ЦТЭ, ЗӨСҮТ, Багануур, Налайх дүүргийн ЭМТ, Улаанбаатар хотын 12 ӨЭМТ, Хэнтий аймгийн НЭ, ӨЭМТ, Жаргалтхаан сумын ЭМТ, Дундговь аймгийн НЭ, ӨЭМТ, Дэлгэрхангай сумын ЭМТ, Өмнөговь аймгийн БОЭТ, ӨЭМТ, Ханбогд сумын ЭМТ-үүдэд эрх зүйн орчны үнэлгээг ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хийж байна.

Дөрөв. Дүгнэлт

"Шинэ сэргэлтийн бодлого" нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийн эхний үе шатны үйл ажиллагаанд хамаарах эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлж байгаа 18 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 86.7%-тай байна.

Эдгээр үйл ажиллагаанаас "Төрийн бүтээмжийн сэргэлт"-д тусгагдсан үйл ажиллагаанууд хамгийн өндөр хувьтай буюу 96.2%-тай хэрэгжиж байна. Тухайлбал:

- "Цахим үндэстэн" болох арга хэмжээний хүрээнд E-Mongolia цахим системийг ашиглан шинжилгээний хариу, эмнэлгийн магадалгаа, цусны бүлгийн мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах, эмнэлгийн цаг захиалах, цаг цуцлах, вакциний гэрчилгээ авах, олон улсын аялалын гэрчилгээ авах, эрт илрүүлэх үзлэг, оношилгооны асуумж бөглөх, дүгнэлт авах зэрэг нийт 12 үйл ажиллагааг төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцон нэг системээр үзүүлж байна.
- Эрүүл мэндийн салбарт мэргэжлийн холбоод, ТББ-аар эрх шилжүүлэн гүйцэтгүүлж байгаа дараах үйл ажиллагаанууд байна. Үүнд: Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэргийн шалгалтыг нийгэмлэг, холбоо, салбар зөвлөлөөр; "Эмнэлгийн мэргэжилтний багц цагийн сургалт"-ыг 73-ТББ, ЭМЯ харъяа-20, Нийслэлийн харъяа-2, Анагаахын боловсрол олгох их дээд сургууль-5, БОЭТ-5, Улсын клиник-3, Хувийн байгууллага-7, Бусад-3, нийт 118 байгууллагаар; эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийг сонгогдсон шинжээч нараар гүйцэтгүүлж байна.
- Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг цахимжуулах, ил тод, шуурхай болгох, хүнд суртлыг арилгах, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор "АКСИС СИСТЕМС" ХХК-тай хамтарч программ хангамжийг хөгжүүлэн <https://tzmoh.gov.mn/> цахим хуудсаар

тусгай зөвшөөрөл шинээр хүсэх, эрх сэргээх, хугацаа сунгах, хаягийн өөрчлөлт, нэмэлт чиглэл хүссэн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байна.

Харин “Ногоон хөгжлийн сэргэлт”-д тусгагдсан үйл ажиллагаанууд хамгийн бага буюу 76%-ийн хэрэгжилттэй байна. Үүнд: Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах үйл ажиллагааны хүрээнд орон нутагт усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд үнэлгээ хийх, үнэлгээний дүнд үндэслэн холбогдох тайлан, зөвлөмжийг өгөх зэрэг ажлууд хийгдэж байгаа ч хэрэгжилт хангалтгүй байна. Нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг барихад эрчим хүчний хэмнэлттэй, саарал усыг дахин ашиглах технологи хэвтрүүлэх ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагаас зөвлөх үйлчигээ авч, барилга байгууламжийн зураг төсөлд техникийн шаардлагуудыг шинэчлэн боловсруулж эхлээд байна.

Шинэ сэргэлтийн бодлого нь 2022 оноос хэрэгжүүлэхээр батлагдсан бөгөөд зарим үйл ажиллагаа нь Эрүүл мэндийн яамны төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд хэрэгжээд явж байна. Харин зарим үйл ажиллагаа нь Шинэ сэргэлтийн бодлогод шууд хамаарахгүй ч салбарын хэмжээнд тухайн үйл ажиллагаанд хамаарах арга хэмжээг үнэлсэн болно. Тухайлбал:

- Аж үйлдвэржилтийн сэргэлт хэсгийн Зорилт 3.5-д “Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ” – гэсэн үйл ажиллагаа төлөвлөгдсөн ба эрүүл мэндийн салбараас эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд шууд утгаараа оролцохгүй ч адууны дайвар түүхий эдийг экспортлох, импортлох үеийн ариун цэврийн шаардлагын талаарх стандарт, журмыг хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чухал юм. Иймээс хүнсний аюулгүй байдал, хүнсний сав баглаа боодлын шаардлага стандартыг шинэчлэх чиглэлээр ХХААХҮЯ, ШӨХТГ, СХЗГ-уудтай хамтран ажиллаж байна.
- Хот, хөдөөгийн сэргэлт хэсгийн 4.4.1-т “Тэжээлийн ургамал, эмийн ургамал тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, загас үржүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдийг бодлогоор дэмжих” гэж тусгагдсан ба эрүүл мэндийн салбар нь энэ чиглэлээр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд уламжлалт эмийн үйлдвэрүүдийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тайлагнасан болно.

Тав. Зөвлөмж

- Боомтуудын КОВИД-19 халдварын болон байгалийн голомтот халдварын лабораторийн үйл ажиллагааг байнгын бэлэн байдалд байлгах. Үүнд: шаардлагатай нөхцөлд халдвар илрүүлэх, шинжилгээ хийх шинжилгээний тоног төхөөрөмж, урвалж оношлуур, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах.
- Сумдын Эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх. Үүнд: шинээр баригдах барилгын зураг төсөлд шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг анхнаас нь төлөвлөж оруулах, хуучин барилгатай эмнэлгүүдийн ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар шинэчлэх
- Шинээр баригдах эмнэлгийн барилга байгууламжид нүүрстөрөгчийн хийн ялгарал багатай технологи нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Налайх дүүргийн Цэцэрлэгт хүрээлэн, “Баянгол агропарк” цэцэрлэгт хүрээлэнд тарьж суулгасан мод бутыг байнга арчлан хамгаалах, ургуулахад анхаарах
- Эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр төсөлд хамрагдаагүй орон нутгийн эмнэлгүүдийн хог хаягдлын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх
- Мэргэжлийн холбоонд эрхээ шилжүүлэн хийлгэх боломжтой төрийн чиг үүргийн талаарх судалгааг гаргасан ба уг үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэх
- Тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг бүрдүүлж, баяжуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Эрүүл мэндийн салбарт авилга, ашиг сонирхлын зөрчлийг бууруулж, авлигын гэмт хэрэг бууруулах зорилгоор сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах

Эрүүл мэндийн яам

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

2023-11-15

**“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ
(ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР)**

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
НЭГ. БООМТЫН СЭРГЭЛТ						
Зорилт 1.1.Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.						
1.1.5	Боомтуудын үндсэн байгууламж /эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, интернэтийн сүлжээ, гаалийн лаборатори, зорчигч болон ачаа тээврийн терминал/-ийг өргөтгөн шинэчилж, зорчигч аялах, албан хаагчдын ажиллах ая тухтай орчныг бүрдүүлэх	Зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадал 3 дахин нэмэгдсэн байна.	Шаардлагатай боомтуудад байгалийн голомтот халдварын болон КОВИД-19 халдварын лаборатори байгуулах, үйл ажиллагааг хангах	Шаардлагатай боомтуудад байгалийн голомтот халдварын болон КОВИД-19 халдварын лаборатори байгуулах ажлыг эхлүүлж, санхүүжилт, удирдлага зохион байгуулалтаар хангасан байна.	<ul style="list-style-type: none"> - Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги, Бичигт, Замын-Үүд автозамын боомтуудыг 2021-2022 онд БНХАУ-ын ЗГ-ын буцалтгүй тусламжаар бүрэн автомат ПГУ шинжилгээний төхөөрөмж (FQD-G1600)-ийн иж бүрдлээр хангасан. Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтын молекул биологийн суурин лаборатори нь өдөрт дунджаар 800 орчим хүнд шинжилгээ хийх хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж байсан. 2022 онд лабораторийн ба тархвар судлаач эмч зэрэг бүрэлдэхүүнтэй баг 31 удаа 14-21 хоногийн хугацаатайгаар томилогдон ажилласан ба 262,430 ПГУ шинжилгээ хийснээс 6,559 эерэг тохиолдлыг бүртгэн мэдээлсэн байна. “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн үйлчлэх хугацааг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тул 2023 он гарсаар тус лабораторийн үйл ажиллагааг зогсоогоод байна. - Шуурхай удирдлагын нэгжгүй Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Сүхбаатар, Увс гэсэн 13 аймагт нэгж байгуулахад шаардлагатай SMART интерактив дэлгэц, суурин болон зөөврийн компьютер, хувилагч, хэвлэгч машин, зургийн аппарат, суурин болон зөөврийн компьютер зэрэг 18 нэр төрлийн 217 ширхэг 915,700,500 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг 	70

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
					<p>Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/60 дугаар тушаалаар хуваарилсан байна.</p> <p>– Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Төв аймагт 33 орон тоо бүхий “Зоонозын өвчин судлалын төв” болон хилийн 12 боомтод 8 орон тоо бүхий “Тандалтын нэгж”-ийг тус тус байгуулж, Ховд, Увс, Өмнөговь, Дундговь, Архангай аймгийн “Зоонозын өвчин судлалын төв”-д барилга, байгууламж барихад шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг шийдвэрлэх тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал хүргүүлсэн боловч Төрийн хэмнэлтийн хуулийн зарчмын хүрээнд батлагдаагүй байна.</p>	
ГУРАВ. АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН СЭРГЭЛТ						
Зорилт 3.5. Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.						
3.5.4	Адууны дайвар түүхий эдийг экспортлох, үеийн хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протоколыг Бүгд Найрамдах Хятад Ард Улстай байгуулах	Малын гаралтай экспортын бүтээгдэхүүн ий нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдсэн байна.	Хүнсний аюулгүй байдлын стандарт шинэчлэх	Хүнсний аюулгүй байдлын стандарт шинэчлэгдсэн байна	<p>Хоол хүнсний аюулгүй байдлыг хангах, техникийн зохицуулалтыг шинэчлэн батлах ажлын хүрээнд Стандарт хэмжил зүйн газарт дараах стандартуудад санал хүргүүлж хамтран ажилласан. Үүнд:</p> <p>- Сүүн, сүүн бүтээгдэхүүний стандартчиллын дэд хорооны хурлаар хэлэлцүүлэх 4 стандартын төсөлд санал боловсруулж, 2/1651 дугаар албан бичгээр СХЗГ-т санал хүргүүлсэн.</p> <p>- Хүнсний стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэх 2 стандартын төсөлд санал боловсруулж, 2/1650 дугаар албан бичгээр СХЗГ-т санал хүргүүлсэн.</p> <p>- “Хүнсний боловсруулах бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх (сүү, гурил, хоол үйлдвэрлэл) заавар”-ын төсөлд 1а/480 дугаар албан бичгээр ХХААХҮЯ-нд санал хүргүүлсэн.</p> <p>- “MNS 7005: 2023 “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага” стандартыг боловсруулах ажлын хэсэгт хамтран</p>	70

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
					ажилласан ба стандарт нь 2023 оны 5 дугаар сарын 3-нд батлагдсан. Мөн Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 05 дугаар сарын 09-ний өдрийн А/226 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу 2022 оны Мэргэжлийн хяналтын байгууллагаас эрхийг нь цуцалсан мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүд, мах бөөнөөр худалдах төвийн үйл ажиллагаанд; мөн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оын 10-00-02/29 дугаартай “Улсын хэмжээнд мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу ХХААХҮЯ, ЭМЯ, БОАЖЯ-ны хамтарсан хяналтын ажлын хэсэг 21 аймаг 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй нийт 249 мах боловсруулах, мал төхөөрөх үйлдвэрүүдэд холбогдох журам, стандартын хэрэгжилтэд шалгалт хийж үнэлгээ дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг хүргүүлж ажилласан. Шалгалтын мөрөөр ХААЯ-нд бодлого боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой холбогдох 15 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.	
Зорилт 3.6.Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, блокчейн, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ.						
3.6.1	Инновац, Аж үйлдвэрийн IV хувьсгал, хиймэл оюун, блокчейн зэрэг технологийн хөгжилд түшиглэсэн шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх	Мэдээллийн технологийн салбарын бүтээгдэхүүн ий экспорт нэмэгдсэн байна.	Эрүүл мэндийн салбарт програм хангамж үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүд мэдээлэл солилцооны платформд өгөгдлийн	Мэдээлэл солилцооны платформд өгөгдлийн солилцох боломж бүрдсэн байна.	Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд мэдээлэл солилцооны платформд өгөгдөл солилцох FHIR стандартыг ЭМЯ-ны стандартын хороогоор батлуулсан. Өгөгдөл солилцооны платформ НIEP-д эрүүл мэндийн бүх байгууллага дээрх стандартыг мөрдөж хоорондоо холбогдон ажиллаж мэдээлэл солилцох боломж бүрдсэн. 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хойш орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт цахим систем ашиглан мэдээллийг амжилттай солилцон	100

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
			стандартыг боловсруулах		<p>ажиллаж байна. Үүнтэй холбоотой мэдээллийн технологийн мэргэжилтнүүдэд мэдээллийн сүлжээ болон аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн салбарт ашиглаж буй програм, техник хангамж ашиглах чадавхийг бэхжүүлэх тасралтгүй сургалтуудыг байнга зохион байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарын цахим шилжилт эрчимтэй хийгдэж байгаатай холбоотой мэдээллийн технологийн мэргэжилтэн, биостатистикч нарын чадавхыг бэхжүүлэх асуудал чухал байна. Иймд 2023 оны 4-6 дугаар сард “IT Admin”-ны болон салбарын цахим шилжилт, мэдээллийн аюулгүй байдал, цахим хөгжлийн багц хуулийн өөрчлөлт, шинэчлэлийн талаарх танхимын сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Цаашид мэдээллийн технологийн чиглэлээр бусад олон улсын туршлага судлах богино хугацааны сургалтыг 2023 оны 11 дүгээр сараас 2024 оны 3 сар хүртэлх хугацаанд зохион байгуулахаар ажиллаж байна. Эхний ээлжид “Метронетворкс” ХХК-тай хамтран мэдээллийн технологийн мэргэжилтэн, биостатистикч нарыг Бүгд Найрамдах Солонгос Улсын “Жусон их сургуулийн эмнэлэг”, Эрүүл мэндийн нийгэмлэгийн харьяа “Гвангжу Чоннам бүс нутгийн MediCheck багц шинжилгээний төв”, Гвангжу хотын “Эрүүл мэндийн даатгалын газар”, Халлим их сургуулийн “Кандун соншим эмнэлэг”, “Янгжи эмнэлэг” зэрэг байгууллагын эрүүл мэндийн даатгалын систем, эмнэлгийн мэдээллийн систем, нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн систем, онлайн эмнэлгийн системтэй танилцах, туршлага судлах сургалтад хамруулахаар зохион байгуулалтыг ханган ажиллаж байна.</p>	

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
ДӨРӨВ. ХОТ, ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ						
Зорилт 4.3.Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ.						
4.3.2	Сумдын инженерийн дэд бүтцийн хангамжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж, хэрэглэгчдэд иж бүрэн, чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх	Хэрэглэгчдийг нийтийн аж ахуйн иж бүрэн үйлчилгээгээр хангасан байна.	Сумдын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламж шинэчлэх	Сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн зураг төслийн даалгаврыг боловсруулсан байна	Улсын хэмжээнд 330 сумын эрүүл мэндийн төвүүдийн ариун цэврийн байгууламжийн судалгааг бүрэн гаргаж дууссан. “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2019 оны судалгаа”-аар нийт сумын эрүүл мэндийн төвийн 19% нь төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон бол 81% нь хэсгийн усан хангамжийн системтэй байна. “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2019 оны судалгаа”-аар нийт сумын эрүүл мэндийн төвийн 19 хувь нь төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон бол 81 хувь нь хэсгийн усан хангамжийн системтэй байна. Иймээс “Эрүүл мэндийн салбарт 2023-2026 онд хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэл”-д Нийгмийн эрүүл мэндийн мэндийн тусламж, үйчилгээний чиглэлээр “Эрүүл мэндийн анхан шатны байгууллага, алслагдсан нутаг дэвсгэрт байрлах эрүүл мэндийн байгууллага болон сумын эрүүл мэндийн төвийн усан хангамж, ариун цэврийн байгууламж”-ийг нэгдсэн байдлаар зохион байгуулж, шинэчлэх асуудлыг тэргүүлэх чиглэл болгон тусгасан. Сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийн зураг төслийн даалгаврыг боловсруулан, нэг маягийн зураг төслийг 2022 онд боловсруулж дууссан. Санхүүжилтийн тооцоог боловсруулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусгуулахаар санал хүргүүлсэн боловч эх үүсвэр батлагдаагүй. Төсөл нь бусад салбарын ариун цэврийн байгууламж болон “Шинэ сум” төсөлтэй уялдах тул Барилга, хот байгуулалтын яаманд цогц хэлбэрээр хэрэгжүүлэх тухай хүсэлтийг хүргүүлээд байна.	70

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
Зорилт 4.4.Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.						
4.4.1	Тэжээлийн ургамал, эмийн ургамал тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, загас үржүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдийг бодлогоор дэмжих	3500 га-аар жимсний талбайг нэмэгдүүлж, 450 байршилд агро ойн аж ахуйг хөгжүүлж, 120 га талбайд тариалангийн талбайн хамгаалалтын зурвас байгуулсан байна.	Эмийн ургамлын тариалалтыг дэмжих	Эмийн ургамлыг тариалахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна.	Уламжлалт эмийн 7 үйлдвэр нь 2022 онд нийт 66 га талбайд давхардсан тоогоор 64 төрлийн эмийн ургамлыг тарималжуулсан ба жилд дунджаар 6 тонн орчим эмийн түүхий эдийг хурааж авч байна. Энэхүү уламжлалт эмийн үйлдвэрээс гадна Монос фарм ХХК, Тавин-Ус ХХК-иуд нь нийт 120 гаруй га талбайд 8 төрлийн эмийн ургамлын масс тариалалт хийж байна. 2023 онд дээрх үйлдвэр, компаниуд шинээр 10 төрлийн эмийн ургамлыг нэмж тарималжуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 4.3.4 дүгээрт “уламжлалт эм болон импортыг орлох эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг дэмжих”; Эм, биобэлдмэлийг зах зээлд гаргах зөвшөөрлийн тухай 8 дугаар зүйлийн 8.15.1 дүгээр заалтад “Уламжлалт эмийн түүхий эд”-д зах зээлд гаргах зөвшөөрөл шаардахгүй байхаар тус тус тусган эрх зүйн орчин бүрдүүлэхээр ажиллаж байна.	100
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ						
Зорилт 5.1.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.						
5.1.1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж, арчилж ургуулах ажлыг нарийвчилсан	Шинээр тарьж, арчилж ургуулсан мод, ойгоор бүрхэгдсэн	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд Эрүүл мэндийн байгууллагуудын оролцоо	Шинээр тарьж, арчилж	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 онд Эрүүл мэндийн яам болон түүний харьяа байгууллагууд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 500 мод, Налайх дүүргийн “Цэцэрлэгт хүрээлэнд” 80 гаруй шинэс модыг тарьж суулгасан бол 2023 онд “Баянгол агропарк” цэцэрлэгт хүрээлэнд 7 төрлийн 4500 ширхэг мод тарьж суулгасан байна.	100

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
	стратеги, төлөвлөгөөний хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэх	талбайн хэмжээ нэмэгдсэн байна.		ургуулсан мод,бут		
Зорилт 5.2.Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усан хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.						
5.2.1	Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулж, нөөцийн хуримтлал бий болгох	Хамгаалалта д авсан гол мөрний урсац бүрэлдэх эх, ус хангамжийн эх үүсвэрийн болон томоохон голуудад барьсан усан сангийн тоог нэмэгдүүлж, эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлсэн байна.	Хот суурин газрын хүн амынундны усны чанар, аюудгүй байдалд эрсдэлд суурилсан хяналт хийнэ	Хамрагдсан объектын тоог өмнөх оноос нэмэгдүүлж, шаардлага хангаагүй дээжийн эзлэх хувийг 8-аар бууруулсан байна.	Эрүүл мэндийн яамнаас ундны усны чанар, аюулгүй байдалд жилд дунджаар 1600 гаруй дээжинд хими, нян судлалын үзүүлэлтээр шинжилгээ хийлгэн үнэлгээ дүгнэлт өгч байна. 2022-2023 онд нийт 1665 дээжинд шинжилгээ хийлгэсэн ба 8,2% нян судлалын үзүүлэлтээр, 21% нь химийн үзүүлэлтээр /хатуулаг, магни, төмөр/ ундны усны стандартын шаардлага хангахгүй гарч байна. Мөн хүнд металл болох хүнцлийн агууламж 17 сумын 34 худгийн ус, ураны агууламж 42 сумын 68 худгийн ус, хар тугалга 22 сумын 29 худгийн усанд стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их гарч байна. Фтор-ын агууламж шинжилгээнд хамрагдсан ундны усны эх үүсвэрийн 145 /17%/ худгийн усанд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их, 408 /51%/ худгийн усанд зөвшөөрөгдөх доод хэмжээнээс бага, 290 /32%/ худгийн усанд зөвшөөрөгдөх хэмжээнд байна. Ундны усны эх үүсвэрүүдэд хийсэн шалгалтаар Нийслэлийн төвлөрсөн ус хангамжийн Гачууртын, А, Б, В эх үүсвэр, аймаг сумын ундны усны эх үүсвэрийн худгийн 466 ба 31.2% нь бүсийн дэглэм зөрчсөн, мөн усан сангийн угаалга халдваргүйжүүлэлт хангалтгүй, төвлөрсөн ус хангамжийн усанд халдваргүйжүүлэлт хийдэггүй, шугам сүлжээний /ялангуяа шинэ барилга/ угаалга халдваргүйжүүлэлт хангалтгүй зэрэг зөрчлүүд илэрдэг. Мөн хөдөөгийн хүн ам хөдөө аж ахуйн зориулалтаар гаргасан /ундны бус/ эрүүл ахуйн шаардлага хангахгүй, шинжилгээ баталгаажилтгүй усыг хэрэглэж, өвлийн улиралд усны хомсдолд орж байгаагаас уснаас шалтгаалах өвчин эмгэгт өртөх нөхцөл бүрдсэн байна.	70

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
					Хяналт шалгалтын дүнд үдэслэн ус хангагч ААН-д жилд дунджаар 230 дүгнэлт, 36 албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна.	
5.2.2	Нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг барихад эрчим хүчний хэмнэлттэй, саарал усыг дахин ашиглах технологийн шаардлагыг хангах	Нийгмийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг ногоон технологийн дагуу барьж, урсгал зардлыг бууруулсан байна.	Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжийг ногоон технологийн дагуу барих	Эмнэлгийн барилга байгууламжид нүүрстөрөгчийн хийн ялгарал багатай технологи нэвтрүүлж эхлэх	Эрүүл мэндийн салбарт АХБ-ны дэмжлэгтэй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төсөл хэрэгжиж байна. Энэ төслийн хүрээнд Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлэг, Увс, Ховд аймгийн нэгдсэн эмнэлэг, 10 өрхийн эрүүл мэндийн төв (Баянзүрх дүүргийн 2, Сонгинохайрхан дүүргийн 1, Чингэлтэй дүүргийн 2, Хан-Уул дүүргийн 3, Баянгол дүүргийн 2), 6 сумын эрүүл мэндийн төв (Архангайн Эрдэнэмандал, Булганы Дашинчилэн, Дорноговийн Эрдэнэ, Хөвсгөлийн Тариалан Ринчинлхүмбэ, Өвөрхангайн Баян-Өндөр), Үндэсний түргэн тусламжийн төвийн барилгын ажил 2019-2029 онд хийгдэнэ. Эдгээр барилгуудыг барихад “нүүрстөрөгчийн хийн ялгарал багатай технологи” (LCT–Low carbon technology) нэвтрүүлэх бөгөөд энэ чиглэлээр Японы “Azusa Sekkei” компанитай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогоор ХУД-ийн Нэгдсэн эмнэлэг, ХУД-ийн 14-р хорооны ӨЭМТөвийн барилгын зурагт LCT технологи нэвтрүүлэхтэй холбоотой ажлын зураг, техникийн шаардлагуудыг сайжруулж боловсруулаад байна.	50
Зорилт 5.3. Байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулна.						
5.3.1	Нийслэл хот болон аймгийн төвүүдэд хог хаягдлыг ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах, дахин	Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээг 27 хувьд	Эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулах	Орон нутагт эмнэлгийн хог хаягдлын барилга	Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр-5 төслийн “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах” зорилтын хүрээнд орон нутагт 8 аймгийн (Дархан-Уул, Булган, Орхон, Сэлэнгэ, Өмнөговь, Дорноговь, Хэнтий, Увс) эмнэлгийн хог хаягдлын 521,3 м2 талбай бүхий барилгын ажлыг нийтдээ 1,2 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэн, 2019-2020	

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
	боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжиж, хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах	хүргэсэн байна.		байгууламж, тоног төхөөрөмж шинэчлэгдсэн байна.	онд байнгын ашиглалтанд оруулсан бөгөөд энэ жишгээр үлдсэн аймгуудад эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулахаар ажиллаж байна. Тухайлбал, Эрүүл мэндийн байгууллагуудын аюултай хог хаягдлын ангилан ялгалт, цуглуулалт, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, устгалын чадавхийг сайжруулах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор ХӨСҮТ, УГТЭ, ЦТЭ, ЗӨСҮТ, Багануур, Налайх дүүргийн ЭМТ, Улаанбаатар хотын 12 ӨЭМТ, Хэнтий аймгийн НЭ, ӨЭМТ, Жаргалтхаан сумын ЭМТ, Дундговь аймгийн НЭ, ӨЭМТ, Дэлгэрхангай сумын ЭМТ, Өмнөговь аймгийн БОЭТ, ӨЭМТ, Ханбогд сумын ЭМТ-үүдэд эрх зүйн орчны үнэлгээг ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хийж байна.	70
Зорилт 5.4.Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлно.						
5.4.1	Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор байгаль орчны хяналт, шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгон хэрэгжүүлэх	Байгаль орчны хяналт, шинжилгээ, үнэлгээ сайжирсан байна.	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийн тандалт судалгаа	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийн үнэлгээний журам шинэчлэгдсэн байна.	“Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, үнэлгээ хийх байгууллага сонгон шалгаруулах журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн А/142 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ нь үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга замыг тодорхойлох, эерэг нөлөөллийг дэмжихэд чиглэгдэж байна. Шинэчилсэн журмыг БОАЖЯ, АШУҮИС, ОБЕГ, Мал эмнэлгийн ерөнхий газар, Цөмийн энергийн комисс зэрэг байгууллагад 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 6/1807 тоот албан бичиг хүргүүлж, санал авсны үндсэн дээр Эрүүл мэндийн сайдын 2023 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн А/169 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан ба “Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын төслийг боловсруулахаар ажиллаж байна.	90
ЗУРГАА. ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ						

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
Зорилт 6.1.Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна.						
6.1.1	“Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр нээлтээ хийсэн төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох “E-Mongolia”-д нэвтрүүлсэн төрийн 57 байгууллагын 563 үйлчилгээг 1000-д хүргэн нэмэгдүүлж, цахим гэрээ хэлцлийг байгуулах нөхцөл бүрдэж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч төрийн үйлчилгээг шуурхай авах нөхцөл бүрдсэн байна.	Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулж, “E-Mongolia”-д нэвтрүүлэх	Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулж, “E-Mongolia” цахим системээр үйлчилгээ үзүүлэх	<p>E-Mongolia-г ашиглан эмнэлгийн цаг захиалах боломжийг бүрдүүлж Эрүүл мэндийн яамны харьяа төрөлжсөн мэргэшлийн төвүүд болон нийслэлийн 9 дүүргийн эмнэлгийн цагийг цахимаар захиалж байна. Мөн төрийн үйлчилгээний E-Mongolia цахим системийг ашиглан шинжилгээний хариу, эмнэлгийн магадалгаа, цусны бүлгийн мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын төлөлт шалгах, эмнэлгийн цаг захиалах, цаг цуцлах, вакциний гэрчилгээ авах, олон улсын аялалын гэрчилгээ авах, эрт илрүүлэх үзлэг, оношилгооны асуумж бөглөх, дүгнэлт авах зэрэг нийт 12 үйл ажиллагааг төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцон нэг системээр үзүүлж байна. Тус үйлчилгээ нэвтэрснээр давхардсан тоогоор 3,759,340 удаагийн эрүүл мэндийн үйлчилгээг иргэд цахимаар аваад байна. 2023 оны эхний хагас жилд дараах үйл ажиллагааг нэмэлтээр хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эмнэлэгт өвчтөн илгээх AM-13A маягтыг цахим хэлбэрт оруулж, эрүүл мэндийн байгууллага хооронд цахимаар илгээж, дамжуулан олгож эхэлсэн - Эмнэлгийн мэдээллийн систем E-health програм хангамжид бичигдсэн эмийн жорыг цахим хэлбэрт оруулж, иргэнд олгох, эмийн сангийн програмтай холбохоор ажиллаж байна. - Импортын эмийн бүртгэл, импортын эмийн өөрчлөлт, импортын эмийн хугацаа сунгалт, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бодис, угтвар бодис болон эм үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх, худалдах гэх зэрэг тусгай зөвшөөрөл хүсэх үйл ажиллагааг цахимжуулсан. - Иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлын хүрээнд Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа 14,160 эмч, эмнэлгийн ажилтанд тоон гарын үсэг олгож өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байгаа эмнэлгийн 	100

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
					мэдээллийн систем “e-health”-д нэвтрэхэд цахим гарын үсэг ашиглах боломжийг нэвтрүүлсэн.	
Зорилт 6.2.Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.						
6.2.1	Мэргэжлийн холбоонд эрхээ шилжүүлэн хийлгэх боломжтой төрийн чиг үүргийн талаарх судалгааг салбар бүрээр гаргаж, шилжүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлэх	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоонд шилжүүлж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, төрийн албыг цомхон, чадварлаг болгох боломжийг нэмэгдүүлсэн байна.	Мэргэжлийн холбоонд эрхээ шилжүүлэн хийлгэх боломжтой төрийн чиг үүргийн талаарх судалгааг гаргах, шилжүүлэх	Мэргэжлийн холбоонд эрхээ шилжүүлэн хийлгэх боломжтой төрийн чиг үүргийн талаарх судалгааг гаргаж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	Эрүүл мэндийн салбарт мэргэжлийн холбоод, ТББ-аар эрх шилжүүлэн гүйцэтгүүлж байгаа дараах үйл ажиллагаанууд байна. Үүнд: - Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэргийн шалгалтыг 2023-2025 онд зохион байгуулах дараах нийгэмлэг, холбоо, салбар зөвлөлийг сонгон эрх олгосон. Үүнд: Дотрын анагаах судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл, Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн салбар зөвлөл, Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Сэтгэц судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Хавдар судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөр гүйцэтгүүлж байна. - “Эмнэлгийн мэргэжилтний багц цагийн сургалт”-ыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаал, “Журам батлах тухай, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 2015 оны 97/56 дугаар тушаалыг үндэслэн 73-ТББ, ЭМЯ харъяа-20, Нийслэлийн харъяа-2, Анагаахын боловсрол олгох их дээд сургууль-5, БОЭТ-5, Улсын клиник-3, Хувийн байгууллага-7, Бусад-3, нийт 118 байгууллагаар гүйцэтгүүлж байна. - Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийг “Магадлан итгэмжлэлийн шинжээч” нараар гүйцэтгүүлж байна. ЭМС-ын 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А/46	100

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
					тоот тушаалаар томилогдсон 97 шинжээч, 2023 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн А/158 тоот тушаалаар томилогдсон 46 шинжээч, нийт 143 шинжээч ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарт 2023-2026 онд хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэлийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/222 дугаар тушаалаар батлуулсан. Үүнд: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ; Эмнэлгийн тусламж, үйлчилгээ; Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт; Дэмжих үйлчилгээ гэсэн 4 чиглэлээр 20 үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон хувийн хэвшил, төрийн бус байгууллага, нийгэмлэг холбоодор гүйцэтгүүлэхээр тусгасан.	
Зорилт 6.3.Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоож, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна.						
6.3.1	Төрийн үйл ажиллагааг ил тод, шуурхай болгох, төрийн хүнд суртлыг арилгах, бизнес эрхлэгчдийг дэмжих тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тоог 2 дахин цөөрүүлж, цахимаар олгох, сунгах боломжийг бүрдүүлэх	Хуулиар хориглосон, эсхүл зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн үйл ажиллагааг хүн, хуулийн этгээд хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхлэх боломжтой болсон байна.	Эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хялбаршуулах	Эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг цахимжуулсан байна	Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг цахимжуулах, ил тод, шуурхай болгох, хүнд суртлыг арилгах, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор “АКСИС СИСТЕМС” ХХК-тай хамтарч программ хангамжийг хөгжүүлэн 2022.04.01-ний өдрөөс https://tzmoh.gov.mn/ цахим хуудсаар Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр хүсэх, эрх сэргээх, хугацаа сунгах, хаягийн өөрчлөлт, нэмэлт чиглэл хүссэн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байна. Уг програмыг www.license.mn тусгай зөвшөөрлийн нэгдсэн програмд холбож, тайлант хугацаанд 1900 гаруй эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн бүртгэлийг холбоод байна.	100

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
6.3.2	<p>Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт, мэргэжлийн шалгалтын үндсэн дээр болон газар, ашигт малтмал, газрын тос, тэсрэх бодис, тэсэлгээ, банк, санхүү, гааль, үндэсний төлбөрийн систем, хэвлэл мэдээлэл, цөмийн энерги, харилцаа холбоо, тамхи, согтууруулах ундааны үйлдвэрлэл, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагаа эрхлэхээс бусад тусгай зөвшөөрлийг шуурхай олгох нөхцөлийг бүрдүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигч өмнө нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчиж байгаагүй бол тусгай зөвшөөрлийн</p>	<p>Бизнес эрхлэх таатай орчин бүрдсэн байна.</p>	<p>Эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл</p>	<p>Эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хялбаршуулсан байна</p>	<p>2022.04.01-ний өдрөөс https://tzmoh.gov.mn/ цахим хуудсаар Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр хүсэх, эрх сэргээх, хугацаа сунгах, хаягийн өөрчлөлт, нэмэлт чиглэл хүссэн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байна.</p> <p>2022 онд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Хэрэв хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй тохиолдолд зөвхөн зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 3 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгана”, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17.1-д “Тусгай зөвшөөрөл олгосон хугацаанд тухайн байгууллагын үйл ажиллагаанд явцын хяналт, шалгалт хийсэн эрх бүхий мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт”, 19.18-д “Тусгай зөвшөөрлийг тухайн байгууллагад анх удаа олгож байгаа бол гурав, сунгаж байгаа бол таван жилийн хугацаагаар олгоно” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх 55 тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр сунгаж шуурхай шийдвэрлэсэн. 2023 оны эхний 5 сарын хугацаанд ЭМЯ-ны дэргэдэх Тусгай зөвшөөрлийн комиссын хурлыг 3 удаа зохион байгуулж, 26 байгууллагын тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1-т зааснаар 5 жилийн хугацаатай сунгаж, 4 компани, аж ахуйн нэгжид эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, импортлох, ханган нийлүүлэх, завсар үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг шинээр олгосон байна.</p> <p>Мөн Монгол Улсад 2023 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Зөвшөөрлийн тухай хуультай уялдуулан “Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичигт тавигдах шаардлага”-ыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/100-р тушаалаар батлуулан “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэл”-д бүртгүүлэн мөрдөж байна. Тусгай зөвшөөрлийн комиссын</p>	100

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
	хугацааг иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр эрх бүхий байгууллага анх олгосон нөхцөл, хугацаагаар шуурхай сунгах				ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/383-р тушаалаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.	
6.3.3	Тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг бүрдүүлж, нээлттэй байлгах	Бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, ил тод, нээлттэй байдал нэмэгдсэн байна.	Эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл	Эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн сан бүрдүүлсэн байна.	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн програмыг хөгжүүлснээр Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, сунгах, нэр өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг 2022 оны 4 дүгээр сараас эхлэн цахимаар хүлээн авч байна. Тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг бүрдүүлж, нээлттэй байлгах ажлын хүрээнд тусгай зөвшөөрөлтэй нийт 6013 байгууллагын мэдээллийн санг тус программ хангамжид шилжүүлэн, мэдээллийг баяжуулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”-тэй байгууллагуудын мэдээллийг авч, нэгдсэн мэдээллийн сан байгуулахаар ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/383-р тушаалын дагуу “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах байгууллагын бүртгэл, зөвшөөрлийн систем” (tzmoh.gov.mn)-д хөгжүүлэлт хийхээр ажлын даалгаврыг боловсруулж, холбогдох байгууллагаас санал авч байна. Уг програмыг www.license.mn тусгай зөвшөөрлийн нэгдсэн програмд холбож, 1900 гаруй эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн бүртгэлийг холбоод байна.	90
Зорилт 6.4.Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.						

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
6.4.1	Улаанбаатар хотоос бусад орон нутагт ажиллах төрийн албан хаагч Төрийн албаны тухай хуульд заасан ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан бол хугацаанаас өмнө шатлан дэвшүүлэх	Төвлөрлийг сааруулах, ажиллах хүчний эрэлтийг хангасан байна.	Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний орон нутаг руу шилжилт, дэмжлэг, үзүүлэх	Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний орон нутаг руу шилжилт, дэмжлэг, урамшуулал үзүүлэх боломж бүрдүүлсэн байна.	Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдыг дэмжих, ажлын байранд тогтвортой ажиллуулах үүднээс аймгийн болон алслагдсан дүүргийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын албан тушаалын ангилал, зэрэглэлд нэмэлт өөрчлөлт оруулж Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 69 дүгээр тогтоолоор аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн захиргааны дэс түшмэлийн албан тушаал (ТЗ-7 ангилал, зэрэглэл)-аас ахлах түшмэлийн ангилал, зэрэглэл (ТЗ-10)-д шилжүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн ЭМЯ-ны дэргэдэх салбар зөвлөлөөс орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдыг дэмжих, ажлын байранд тогтвортой ажиллуулах үүднээс аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн албан тушаалын сонгон шалгаруулалтын тусгай шалгалтыг 2023 оны эхний хагас жилд 2 удаа зохион байгуулав. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 69 дүгээр тогтоолоор аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн даргын албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн захиргааны дэс түшмэлийн албан тушаал ахлах түшмэлийн ангилал, зэрэглэлд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь орон нутагт ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	90
6.4.2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг үнэ болон бусад нөхцөлийг нийлүүлэгчтэй тохирч 3 жилээр байгуулах зарчимд	Тендерт оролцогчид тавигддаг шаардлагагүй хязгаарлалтыг халж, зарим төрлийн гэрээг шууд 3 жилээр байгуулах боломж	Тендер, худалдан авалт, сонгон шалгаруулалтын хязгаарлалтыг багасгах	Цахим тендер зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хуульд тусгагдаж, батлагдаагүй ба 2022-2023 онд дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 7 төсөл арга хэмжээг 27,3.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэйгээр холбогдох газруудад эрхийг шилжүүлсэн. 7.9 тэрбум төгрөгийн 4 барилга байгууламж, 17.4 тэрбум төгрөгийн 2 их засвар, 2.0 тэрбум төгрөгийн тоног, төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг tender.gov.mn буюу худалдан авах ажиллагааны цахим системээр 100 хувь зохион байгуулж, ил тод байдлыг	100

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
	бүрэн шилжиж, тендерт оролцогчид тавигддаг шаардлагагүй хязгаарлалтыг халж, тендерийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шуурхай болгох	бүрдсэнээр тендерийн үйл ажиллагаа хялбар, хүртээмжтэй болно.			хангаж, тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллаж байна.	
Зорилт 6.5. Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана.						
6.5.1	Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах	Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг буюу Авлигын гэмт хэрэг бүлэгт хамаарах эрүүгийн гэмт хэргийн ялын бодлогыг чангатгасан байна.	Эрүүл мэндийн салбарт авилга, ашиг сонирхлын зөрчлийг бууруулах чиглэлд хийж байгаа ажил	Эрүүл мэндийн салбарт авилга, ашиг сонирхлын зөрчлийг бууруулж, авлигын гэмт хэрэг буурсан байна.	“Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”-г Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран боловсруулж, харьяа эрүүл мэндийн байгууллагын саналыг тусгаж 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдөр батлуулсан ба батлагдсан төлөвлөгөөг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдөр 1а/970 тоот албан бичгээр хүргүүлсэн. Авлига, ашиг сонирхлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны эхний 5 сарын байдлаар 1097 эрүүл мэндийн ажилтанд 2 удаагийн цахим сургалтыг Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан. 2023 оноос эхлэн зөвхөн Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнаар хязгаарлахгүйгээр нийт эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, эрүүл мэндийн бусад ажилтанд чиглэсэн сургалтыг эрүүл мэндийн салбарын эрх бүхий албан тушаалтнууд өөрсдөө зохион байгуулахаар сургагч багшийн сургалтад анх удаа хамруулахаар бэлтгэж байна. Ингэснээр эрүүл мэндийн байгууллагууд өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан авлигын эсрэг сургалт, сурталчилгааг бие даан зохион байгуулах боломжтой болно. Эрүүл мэндийн яам болон харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх үүрэгтэй нийт 553 албан тушаалтан 2022 оны ХАСХОМ-ийг 100% бүрэн мэдүүлж Авлигатай тэмцэх газарт тайлагнасан байна.	90

Д/д	“Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан		Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх үйл ажиллагаа			Үнэлгээ
	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Үйл ажиллагаа	2023 онд хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	
Нийт						86.7



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: letter@moh.gov.mn, http://moh.gov.mn

2023. 11. 30 № 10/5449
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 26 хуудастай


С.ЧИНЗОРИГ



141525121